



СҮМБЭР СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
доорх хаягаар харилцана уу:**

Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа
Утас: 70543156
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер Г.Наранбаяр
Утас: 70543179
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn

Хаяг:
Сүмбэр сум, 3 дугаар баг, Нутгийн
удирдлагын ордон 2 дугаар давхар

АГУУЛГА

ХУУДАС

- Аудитын гэрчилгээ
- Менежментийн захидал
- Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Нэг. Ерөнхий зүйл	
Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ.....	5
Аудитын арга зүй.....	5
ОН-ийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал.....	5
Хоёр. Санхүүгийн дотоод хяналт	6
Гурав. Шилэн дансны мэдээлэл.....	7
Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох.....	8
Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар.....	8
Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	
6.1. Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар	8
6.2. Арилжааны банкин дахь орон нутгийн харилцах дансны талаар	9
6.3 Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар.....	10
Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал	
7.1. Авлагын бүтцийн талаар.....	11
7.2. Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар авлагын бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар.....	12
Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал	
8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар	14
8.2 Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материалын зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар.....	14
Ес. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	
9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар....	15
9.2 Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар	17
Арав. Өр төлбөрийн бүртгэл тайлагналын талаар	
10.1. Өр төлбөрийн бүтцийн талаар	18
10.2. Өр, төлбөрийн бүртгэл тайлагналтай	

холбоотой гарсан зөрчлийн талаар	19
Арван нэг. Орлогын бүртгэл тайлагнал	20
11.1 Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар	21
11.2 Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар.....	21
11.3 Бусад эх үүсвэрийн талаар.....	24
Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал.....	25
12.1 Зардлын бүтцийн талаар.....	26
12.2 Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл,тайлагналтай холбоотой зөрчлүүдийн талаар.....	28
Арван гурав. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар	25
Арван дөрөв: Хуримтлагдсан үр дүнгийн талаар.....	26
Арван тав: Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	26
Арван зургаа: Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт.....	26
Арван долоо. Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт.....	26

Товчилсон үгийн жагсаалт

YAГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
СЯ	Сангийн яам
ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн ОУС
ОН	Орон нутаг
ХО	Хөрөнгө оруулалт
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОННСТ	Орон нутгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан
СНТ	Нэгтгэсэн санхүүгийн тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТББ	Төрийн бус байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
МХС	Мал хамгаалах сан
БХС	Байгаль хамгаалах сан
ЖМС	Жижиг мөнгөн сан

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Сүмбэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд /ГСА-2018/3/СТА-ТТЗ / аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг бүрэн ирүүлсэн бөгөөд эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт болно.

Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай шилжүүлгийн байгууллагууд, ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан, төсөл, сангуудын нийт 12 тайланг хамруулан нэгтгэсэн тайланг аудитласан болно. Үүнд:

- Орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлан 3
- Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлан 6
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн тайлан 1
- Төсөл, сангуудын санхүүгийн тайлан 2

Аудитын арга зүй

Орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

Орон нутгийн 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалыг баримтлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккруэл суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

Орон нутгийн ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ОН-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	Үндсэн хөрөнгө, бараа материал, өр, авлагын тодруулга тайлан байгууллагын төрлөөр
ОН-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	
ОН-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
ОН-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайлангуудаас Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаас бусад тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан аргачлал журамын дагуу “Э-тайлан” програмаар бэлтгэн гаргажээ.

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Санхүүгийн хяналт, аудитын алба” аймгийн ЗДТГ-ын бүтцэд байгуулагдаж, 2017 онд нийт 15 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хамруулан шалгаж, 84,323.9 мянган төгрөгийн зөрчил дутагдал илрүүлж, 23,013.3 мянган төгрөгийн акт бичиж, 61,310.6 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг арилгах зөвлөмж, албан шаардлага өгч ажилласан байна. Тус сумын 5 дугаар сургууль, “Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамрагдсан бөгөөд хяналт шалгалтаар нийтлэг дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Албан томилолтын хоногийг засах, илүү дутуу олгосон, анхан шатны баримтын бүрдлийг хангадаггүй. /Засгийн газрын 218–р тогтоолын 1-р хавсралтаар баталсан журмын 12-р заалт/
- Автомашины шатахууны зарцуулалтыг тооцохдоо нормоос илүү бодож олгосон ба замын хуудсыг бөглөдөггүй. /Дэд бүтцийн сайдын 2004 оны 19-р тушаалаар баталсан жишиг норм /
- Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааны хувьд зарим байгууллага нь огт хийдэггүй, хийсэн байгууллага нь шаардлага хангахгүй санхүүгийн үйл ажиллагаандаа бус үндсэн үйл ажиллагаандаа хийж хангалтгүй ажилладаг /ЗГ-ын 311 дүгээр тогтоол /
- Удирдлагууд хүчингүй болсон хууль тогтоомжийг тушаал шийдвэр дээр ашигласан.
- Ажлаас халагдсан ажилтнуудтай ээлжийн амралтын тооцоо хийдэггүйгээс ээлжийн амралтын олговор дутуу олгодог, мөн ээлжийн амралтын мөнгийг илүү бодож өмнөх жилд бодсон амралтын мөнгийг давхардуулан тооцож олгосон /Хөдөлмөрийн тухай хуулийн 55.1 дэх заалт/зэрэг зөрчлүүд илэрсэн.
- Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл хангалтгүй, үндсэн хөрөнгө коджуулаагүй, элэгдлийн хугацаа дууссан үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу ашиглах боломжгүй болсон хөрөнгийг холбогдох газарт нь санал хүргүүлж

шийдвэрлүүлдэггүй /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 зүйл /зэрэг зөрчлүүд гарч байна

- Шагнал урамшуулал олгохдоо ХХОАТ суутгадаггүй /Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 16.1.1, 23.1, 26.1.1 дэх заалтууд/

Дээрх зөрчлүүдийн улмаас Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалууд зөрчигдсэн байна.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна.

- Төсвийн хэтрэлт хэмнэлтийн тайлбар бичдэггүй /ШДТХуулийн 6.3.3 заалт/
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт байхад хийдэггүй. /ШДТХуулийн 6.4.1 заалт/
- Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана” гэж заасны дагуу мэдээ тайланг хугацаанд нь илгээдэггүй.
- ТТЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллийн 2 нь хугацаа болоогүй бөгөөд 66 буюу 44.8% нь хугацаа хоцроосон мэдээллүүд байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1-дэх заалтыг зөрчсөн байна.

Шилэн дансны мэдээний хугацаа хэтрэлт буурсан боловч хэрэгжилт хангалтгүй байгаа тул хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналтыг сайжруулах, шаардлагатай байна.

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг суурь болгон авч түүний 1.5%-иар тооцон 107,193.1 мянган төгрөгөөр тогтоов.

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсөвт байгууллага, тусгай шилжүүлгийн байгууллага, төрийн сан, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөл, сангуудын нийт 12 байгууллагын тайланг хамрууллаа.

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг хавсарч ирүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу ТТЗ-ийн нэгтгэсэн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт дээрх хугацаанд ирүүлэхээр заасан боловч 2 хоногоор хугацаа хэтэрч ирүүлсэн болно.

Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Орон нутгийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын нярвын данс, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨААТҮГ-ууд болон төсөл сангийн үлдэгдэл,
- ОНӨААТҮГ-уудын кассад байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл.

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2017 оны эхэнд 192,388.7 мянган төгрөг байсан ба тайлант оны эцэст 380,935.2 мянган төгрөг болж 198.0% буюу 188,546.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт үлдэгдлийн 99.9% нь төрийн сангийн нэгдсэн дансанд, 0.1% арилжааны банкинд байршиж байна.

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	(мянган төгрөгөөр)	
				Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө					
Төгрөг/ЖМС	0	0	0		
Касс					
Банкинд байгаа бэлэн мөнгө	192,388.7	380,935.2		315.4	380,619.8
Төгрөг					
Гадаад валют					
Замд яваа мөнгөн хөрөнгө					
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	192,388.7	380,935.2		315.4	380,619.8
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:					
Төрийн сан	40,697.6	153,792.7		315.4	153,477.3
Төсөвт байгууллагууд	40.2	0	0	0	0
ОНӨҮГ	0	0	0	0	0
Төсөл, сангууд	151,650.9	227,142.5			227,142.5

Хүснэгтээс харахад: Төсөвт байгууллагуудын тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь 40.2 мянган төгрөгөөр буурч, төрийн сан дахь дансдын үлдэгдэл 113,095.1 мянга, төсөл сангийн үлдэгдэл 75,491.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

6.2 Арилжааны банкин дахь орон нутгийн харилцах дансны талаар

Төсвийн тухай хуулийн дагуу 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад татварын орлогын данс 315.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Арилжааны банкуудад байршиж буй харилцах дансны үлдэгдлийг хураангуйлан харуулбал:

Сүмбэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Сум	ҮЛДЭГДЭЛ									(мянган төгрөгөөр)
	Бэлэн мөнгөний касс	Жижиг мөнгөн сан	Зөвшөөрөлгүй	ОН-ийн орлого	ОН-ийн халамж	ОН-ийн өмчит үйлдвэрийн газар	Санхүүжилтийн данс	Төсөл сан	Татварын орлогын данс	НИЙТ ҮЛДЭГДЭЛ
Сүмбэр	-	-	-	-	-	-	-	-	315.4	315.4
НИЙТ	-	-	-	-	-	-	-	-	315.4	315.4

Уг үлдэгдэл нь ХААН банкин дахь татварын орлогын дансанд байршиж байгаа бөгөөд төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй үлдэгдэл байна.

Дээрх орлогын үлдэгдэл нь Төрийн сангийн данс хаахтай холбоотой бөгөөд банкинд үлдэгдлийн тохируулга хийдэггүй, өөрийн үлдэгдлээр тайлагнаж, төсөвт орлого хүлээн зөвшөөрч бүртгэх боломжгүй байна.

6.3. Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, зарцуулалттай холбоотой нийт **359,485.4** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **312,810.0** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **1,230.4** мянган төгрөгийн төлбөрийн акт бичиж, **7,418.3** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **37,999.7** мянган төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 100% буюу **359,485.4** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой байна.

Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал

7.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд авлагын эхний үлдэгдэл 986,256.3 мянган төгрөг байсан бол тайлант онд 7.87% буюу 77,632.9 мянган төгрөгөөр буурч, оны эцэст 908,623.4 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Дансны нэр, төрөл	(мянган төгрөгөөр)			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,323.4	1,341.7	-18.3	-1.38%
Байгууллагаас авах авлага	984,932.9	907,281.7	77,651.2	7.88%
Хувь хүмүүсээс авах авлага				

Сүмбэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

НИЙТ ДҮН	986,256.3	908,623.4	77,632.9	7.87%
-----------------	------------------	------------------	-----------------	--------------

Хүснэгтээс харахад: нийт авлагын 99.8%-ийг байгууллагаас авах авлага, 0.2%-ийг ажиллагчидтай холбоотой авлага эзлэж байна.

Хувь хүмүүсээс авах авлагын эцсийн үлдэгдэл эхний үлдэгдлээс 1.38% буюу 18.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, байгууллагаас авах авлага 7.88%-иар буурсан байна.

Авлагыг байгууллагын төрлөөр нь дараах хүснэгтээр харуулбал:

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	(мянган төгрөгөөр)	
				Хувиар	Нийт үлдэгдэлд эзлэх хувь
Сумын ЗДТГ		280.0	(280.00)		0.03
1-р цэцэрлэг	714.3	961.5	(247.20)		0.11
2-р цэцэрлэг		73.0	(73.00)		0.01
2-р сургууль	61.2	100.2	(39.00)		0.01
1-р сургууль	4,275.0	23.2	4,251.80		0.00
5-р сургууль	417.0	464.4	(47.40)		0.05
ОНХСан	28,087.5	28,087.5	-		3.09
Сум хөгжүүлэх сан	952,701.2	878,633.7	74,067.50		96.70
ДҮН	986,256.2	908,623.5	77,632.70	7.87	100.0

Хүснэгтээс харахад: Сум хөгжүүлэх сангийн авлага нийт авлагын 96.7%-ийг эзлэж байна.

Нийт 906,721.2 мянган төгрөгийн авлага нь 91-ээс дээш хоногийн насжилттай байгаа бөгөөд авлагын 0.2% буюу 1,902.3 мянган төгрөг нь ТШЗ, 3.1% буюу 28,087.5 мянган нь ОНХСан, 96.7% буюу 878,633.7 мянган төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл эзэлж байна.

7.2 Сүмбэр сумын ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авлагын бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн тайлангийн аудитаар авлагатай холбоотой 3,174.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 215.3 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 2,959.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах зөвлөмж өгөв.

Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал

8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн тайлангийн бараа материалын эхний үлдэгдэл 649,906.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,015,367.7 мянган төгрөг болж тайлант онд бараа материалын үлдэгдэл 56.2%-иар буюу 365,461.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдлийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

(мянган төгрөгөөр)

Сүмбэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Дансны нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Үлдэгдэлд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	6,607.3	11,932.3	(5,325.0)	1.2
Эм боох материал	2,066.5	2,896.7	(830.3)	0.3
Дуусаагүй үйлдвэрлэл	-	-	-	-
Бэлэн бүтээгдэхүүн	-	-	-	-
Бичиг хэргийн материал	5,705.4	5,681.4	24.0	0.6
Аж ахуйн материал	305,592.6	364,460.9	(58,868.3)	35.9
Сэлбэг хэрэгсэл	76.0	76.0	-	0.0
Түлш, шатах тослох материал	3,762.0	2,773.0	989.0	0.3
Барилгын засварын материал	1,810.4	1,810.4	-	0.2
Хүнсний материал	20,049.7	23,045.0	(2,995.3)	2.3
Бусад хангамжийн материал	230,727.8	243,560.0	(12,832.2)	24.0
Биологийн хөрөнгө	-	-	-	-
Мал амьтад	43,810.0	43,810.0	-	4.3
Нөөцийн бараа	29,698.8	315,322.0	(285,623.2)	31.1
Дүн	649,906.4	1,015,367.8	(365,461.4)	100.0

Хүснэгтээс харахад: Түлш, шатах тослох материал 989.0 мянга, бичиг хэргийн материал 24.0 мянган төгрөгөөр буурч, бусад бараа материал 830.3-285,623.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал нийт дүнгээрээ 760,701.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба худалдаж авсан 396,208.6 мянга, хандив тусламжаар 90,238.3 мянга, шилжүүлж авсан 274.193.3 мянга, бусад хэлбэрээр 61.2 мянган төгрөгийн бараа материал тус тус нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал нийт дүнгээрээ 395,240.0 мянган төгрөгөөр хасагдсан ба зарцуулсан 367,961.8 мянга, шилжүүлсэн 6,784.2 мянга, акталсан 20,493.9 мянган төгрөгөөр тус тус данснаас хасагдсан байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 1,015,367.8 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудын дансанд бүртгэлтэй байна.

8.2 Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бараа материалын зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой нийт **150,516.9** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **45,458.6** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **19,074.7** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **85,983.6** мянган төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 100% буюу 150,516.9 мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой байна.

Ес. Үндсэн хөрөнгийн талаар

9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгө оны эхэнд 16,597,406.6 мянган төгрөг байсан бол тайлант онд 3.35% буюу 556,783.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 109,941.2 мянган төгрөгөөр буурч оны эцэст 17,044,249.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

(мянган төгрөгөөр)

Дансны нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Үлдэгдэлд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	14,148,232.4	14,516,474.5	-368,242.1	85.17
Тээврийн хэсэгсэл	117,556.8	119,336.8	-1,780.0	0.70
Машин тоног төхөөрөмж	1,055,525.1	1,108,521.2	-52,996.2	6.50
Тавилга эд хогшил	445,724.3	458,453.5	-12,729.2	2.69
Түүх соёлын дурсгалт зүйл	0.0	0.0	0.0	0.00
Дуусаагүй барилга байгууламж	0.0	0.0	0.0	0.00
Номын фонд	6,016.7	6,016.7	0.0	0.04
Бусад үндсэн хөрөнгө	795,875.0	807,855.0	-11,980.0	4.74
Програм хангамж	10,936.5	10,051.6	884.9	0.06
Бусад биет бус хөрөнгө	17,540.0	17,540.0	0.0	0.10
Бусад хөрөнгө	0.0	0.0	0.0	0.00
Дүн	16,597,406.7	17,044,249.3	-446,842.7	100.00

Хүснэгтээс харахад: Нийт үндсэн хөрөнгийн 85.17%-ийг барилга байгууламж, 2.69%-ийг тавилга, эд хогшил, 6.5%-ийг машин тоног төхөөрөмж, 0.04%-ийг номын фонд, 0.7%-ийг тээврийн хэрэгсэл, 4.9%-ийг биет бус болон бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд 556,783.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба үүнээс худалдан авсан 16,411.0 мянга, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 447,308.6 мянга, шилжүүлж авсан 92,850.0 мянга, бусад эх үүсвэр буюу данснаас дансанд шилжүүлсэн 214.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт 109,941.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасагдаж, 17,044,249.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тайлант онд 20,591.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 89,350.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлж, 478,312.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

9.2. Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой тус тайланд нэгтгэгддэг байгууллагуудын аудитаар нийт **57,715.2** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад 40,190.5 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг залруулж, **16,674.7** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **850.0** мянган төгрөгийн зөрчил дутагдал арилгах зөвлөмж өгсөн байна.

Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой нийт зөрчил дутагдал ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой байна.

Арав. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

10.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар:

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 71,059.5 мянган төгрөг байснаас тайланд онд 29.9% буюу 21,228.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 92,287.6 мянган төгрөг болсон байна.

Нийт өр төлбөрийн 0.6% буюу 526.4 мянган төгрөгийн өр төлбөр нь 30 хүртэлх хоногтой, 99.4% буюу 91,761.1 мянган төгрөгийн өр төлбөр нь 91-ээс дээш хоногтой байна.

Өр, төлбөрийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Үлдэгдэлд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	71,059.5	92,287.6	-21,228.1	100.0
Өглөг	2,841.9	526.4	2,315.5	0.6
Ажилчидтай холбогдсон өглөг	86.2	526.4	-440.2	0.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,755.7	0.0	2,755.7	
Бусад өглөг	68,217.5	91,761.1	-23,543.6	99.4
Байгууллагад төлөх өглөг	68,217.5	91,761.1	-23,543.6	99.4

Хүснэгтээс харахад: Ажиллагсадтай холбоотой болон бараа үйлчилгээний зардлын өглөг 2,315.5 мянган төгрөгөөр буурсан бол байгууллагад төлөх өглөг 23,543.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөрийн үлдэгдлийг байгууллага тус бүрээр харуулбал:

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Үлдэгдэлд эзлэх хувь
Өрхийн эмнэлэг	210.9	0	210.9	
Орон нутгийн хөгжил сан	9,926.8	37,790.1	(27,863.3)	40.95
ОНХС-ын Барьцаа хөрөнгө	53,543.6	53,939.3	(395.7)	58.45
Байгаль хамгаалах сан	985.0		985.0	
5-р сургууль	3,492.3		3,492.3	
Сумын ЗДТГ	58.9		58.9	
1-р сургууль	2,755.7		2,755.7	
1-р цэцэрлэг		31.7	(31.7)	0.03
2-р цэцэрлэг	86.2	73.0	13.2	0.08
Сумын ИТХурал		453.4	(453.4)	0.49
Дүн	71,059.5	92,287.6	(21,228.1)	100

Хүснэгтээс харахад: Тайлант онд сумын төсөвт байгууллага, төсөл сангуудийн өр төлбөр өмнөх оноос нийтдээ 21,228.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт өр төлбөрийн

0.6% буюу 558.2 мянган төгрөгийг төсөвт байгууллагууд, 99.4% буюу 91,729.4 мянган төгрөгийг төсөл сан тус тус эзэлж байна.

Өмнөх онд нийт өр төлбөрийн 90.7% буюу 64,455.4 мянган төгрөгийг төсөл сангийн өр төлбөр эзэлж байсан бол тайлант онд төсөл сангийн өр төлбөр 99.4% буюу 91,729.4 мянган төгрөгийг эзэлж байна. Төсөл сангийн өр төлбөрийн 41.2% нь орон нутгийн хөгжлийн сангийн, 58.8% нь ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын барьцаа хөрөнгийн өглөг байна. Оны эцэст ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн аваагүй, барьцаа хөрөнгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлээгүй ОНХС-гийн үлдэгдлээр тайлагнасангай холбоотойгоор өр төлбөр нэмэгдсэн байна.

10.2 Өр, төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудитаар өр төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **66,135.6** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **28,980.8** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж **37,154.8** мянган төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 100% буюу **66,135.6** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой байна.

Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

11.1. Сүмбэр сумын ТТЗ-ын 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар:

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд нийт 7,590,476.6 мянган төгрөгийн орлого, санхүүжилт бүртгэсэн байна. Энэ нь өмнөх оноос 499,955.1 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлогын бууралтад үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, тусламж санхүүжилтийн орлого, ОНХС-гийн орлогын шилжүүлэг, Санхүүгийн дэмжлэг зэрэг буурсан нь нөлөөлсөн байна.

Үр дүнгийн тайлангаарх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Татварын орлого	221,282.20	353,969.70	-132,687.50	4.7
Тусламж, санхүүжилтийн орлого	825,327.10	638,193.90	187,133.20	8.4
Санхүүгийн дэмжлэг	463,083.00	355,282.30	107,800.70	4.7
Тусгай зориулалтын шилжүүлэг	4,128,364.70	4,396,866.20	-268,501.50	57.9
ОНХС-гийн шилжүүлсэн орлого	610,434.50	386,355.00	224,079.50	5.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	52,638.70	504,922.70	-452,284.00	6.7
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,684,054.70	859,629.40	824,425.30	11.3
Бусад арга хэмжээ болон зээлийн хүүгийн орлого	36,345.30	25,804.20	10,541.10	0.3
ОНӨААТҮГ-ын цэвэр борлуулалт	68,901.50	69,453.20	-551.70	0.9
Орлогын дүн	8,090,431.70	7,590,476.60	499,955.10	100

Хүснэгтээс харахад: Орлогын бүрдүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад татварын болон татварын бус орлого, ОНӨААТҮГ-ын орлого, нэмэлт санхүүжилт дансны орлого, тусгай зориулалтын шилжүүлэг, бусад арга хэмжээ болон зээлийн хүүгийн орлого тус бүр нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа бол тусламж санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, ОНХС-гийн орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг тус бүр буурсан байна.

Татварын орлогод үйл ажиллагааны орлого 36,042.9 мянга, хөрөнгө борлуулсны орлого 39,694.5 мянга, шууд бус орлого 160,699.6 мянга, бууны албан татвар 3,630.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 14,228.5 мянга, АМНАТ 1,356.0 мянга, хог хаягдлын хураамж 69,453.2 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 28,864.8 мянга нийт 353,969.7 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна.

Татварын бус орлогод сум хөгжүүлэх сангийн зээлээс тооцсон алданги 297.0 мянга, төсөвт байгууллагын арга хэмжээний орлого 1,123.7 мянга, 5-р цэцэрлэгийн актны төлбөр 12,130.4, байгаль хамгаалах сангийн дансны үлдэгдэл төвлөрүүлсэн 12,253.1 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 859,629.4 мянга, ОНӨААТҮГ-ын борлуулалт 69,453.2 мянга, нийт 954,886.8 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна.

Тусламж санхүүжилтийн орлогод тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 4,396,866.2 мянга, ОНХС-гийн санхүүжилт 386,355.2 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 504,922.7 мянга, аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 355,282.3 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилт 638,193.8 мянга, нийт 6,281,620.2 мянган төгрөгийн санхүүжилт бүртгэсэн.

11.1 Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар:

2017 онд Сүмбэр сумын ТТЗ-ийн хэмжээнд нийт 6,398.721.7 мянган төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, зарцуулахаар төлөвлөж, батлуулснаас 5,656,636.0 мянган төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, нийт орлого, санхүүжилтийн төлөвлөгөө 742,085.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

Тайлант хугацаанд татварын орлого 138,669.7 мянган төгрөгөөр давсан бөгөөд Шивээговь сумын Бүжинхэн цэцэрлэгт Сумын ИТХ-аар батлагдаагүй 26,030.3 мянган төгрөгийн санхүүжилт илүү олгож, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгийн орлогын бүрдүүлэлт 906,785.4 мянган төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

2017 онд тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 4,396,866.0 мянга, ОНХС-гийн санхүүжилт 436,299.7 мянга, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 355,282.3 мянга, төгрөг, татварын орлогоос 215,300.0 мянга, нийт 5,403,748.0 мянган төгрөгийн аймгийн болон сумын төсөв хоорондын шилжүүлэг хийхээр төлөвлөж, бүрэн санхүүжсэн байна.

Өмнөх оны тэнцлийн ашиг 90,095.3 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар оны эхэнд 192,388.7 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан ба тайлант онд нийт 6,814,203.8 мянган төгрөгийн орлого бүртгэж, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр 6,087,579.2 мянга, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээгээр 536,305.2 мянга, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр 1,773.0 мянга, нийт 6,625,657.4 мянган төгрөгийн зарлага бүртгэж, 380,935.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Мөнгөн гүйлгээний нийт орлого 6,814,203.8 мянган төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүнээс төсөвт байгууллагуудын орлого, санхүүжилт 5,851,061.9 мянга, нэмэлт дансны санхүүжилт 504,922.7 мянга, татварын орлого 353,969.7 мянга, татварын бус орлого 104,249.4

мянга, төгрөг бүртгэж, буцаан төвлөрүүлсэн буюу тохируулсан 210,246.5 мянган төгрөгөөс бүрдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн орлого нь орон нутгийн төсвөөс 608,410.1 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 4,283,095.1 мянга, ОНХС-гийн санхүүжилт 386,355.0 мянга, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 74,364.6 мянга, нийт 5,352,224.8 мянган төгрөгөөс бүрдсэн байна.

Нэмэлт дансны орлого санхүүжилт нь Эрүүл мэндийн яамнаас 8,050.0 мянга, БСГ-аас 23,040.6 мянга, аймгийн Засаг даргын нөөц сангаас 6,000.0 мянга, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжүүлсэн ажлын санхүүжилт 301,109.3 мянга, төндөрийн баримт бичгийн орлого 944.2 мянга, АИТХ-ын ГХУСАХЗ-ын санхүүжилт 1,300.0 мянга, Сумын ОНХС-аас суурь зарлага 116,514.4 мянга, Авто замын сангаас 47,764.1 мянга, нийт 504,722.6 мянган төгрөгийг тус тус хүлээн авч зарцуулсан байна.

2017 онд орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 215,300.0 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөснөөс 353,969.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 64.4% буюу 138,669.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Татварын орлогын төлөвлөгөө биелэхэд ан амьтны нөөц ашигласны төлбөр, арилжааны банкин дахь хадгаламжаас татвар суутгадаг болсон нь голлох нөлөө үзүүлсэн бөгөөд АМНАТ-аас бусад бүх татварын орлого төлөвлөгөөнөөс давсан байна.

Мөн Татварын бус орлогоор сум хөгжүүлэх санд 980,853.0 мянган төгрөгийг орлогын төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 74,364.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 906,488.4 мянган төгрөгөөр буюу 92.4%-иар дутуу биелүүлсэн байна.

11.3. Бусад эх үүсвэрийн талаар:

Сумын орлогоос гадна төсөвт зардлыг санхүүжүүлэх бусад эх үүсвэр батлагдаагүй байна.

Сүмбэр сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүний бүртгэл тайлагналтай холбоотой нийт **1,357,922.3** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **419,435.0** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **938,487.3** мянган төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв

Нийт зөрчил дутагдлын 24% буюу **326,115.6** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 75.9% хувь буюу **1,031,806.7** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- 2017 онд сумын ИТХ-ын төсөв батлах тогтоолд батлагдаагүй 26,030.3 мянган төгрөгийн санхүүжилтийг Шивээговь сумын Бүжинхэн цэцэрлэгт олгосон зөрчил илэрлээ.
Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- Сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг 906,488.4 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 74,064.6 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэсэн байна.
Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

- Арилжааны банкин дахь хадгаламжийн хүүгээс тооцсон 25,220.5 мянган төгрөгийн татварын орлогыг татварын бус орлогоор бүртгэсэн зөрчил илэрлээ.
Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал

12.1. Зардлын бүтцийн талаар:

Сүмбэр сумын ТТЗ-ийн тайланд 10 төсвийн байгууллагад 6,000,400.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж 2 удаагийн төсвийн тодотголоор нийт 398,320.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 6,398,721.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Төсвийн тодотголоор нийт 398,320.8 мянган төгрөг нэмэгдсэн бөгөөд Тохижилт сүмбэр ОНӨААТҮГ-ын цалин, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, урсгал завсарын зардалд 43,600.0 мянга, 1,2,5 дугаар сургуульд нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 64,239.2 мянга, ОНХСан 201,793.8 мянга, 1,2,5 дугаар цэцэрлэгт 1 удаагийн тэтгэмж урамшуулал 28,200.0 мянга, сумын ИТХ-ын урсгал засвар, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 2,265.0 мянга, сумын ЗДТГ-ын цалин сан, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 25,877.8 мянга, сум хөгжүүлэх сан 47,543.0 мянга, нийт 413,518.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, мал хамгаалах сан 3,000.0 мянга, байгаль хамгаалах сан 12,198.0 мянга, нийт 15,198.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд төсвийн 10 байгууллага 2 сангийн үйл ажиллагааны зардалд 6,398,721.6 мянган төгрөгийг зарцуулахаас 5,277,169.2 мянган төгрөгийг зарцуулж, 1,121,552.4 мянган төгрөгийг хэмнэж, сумын ерөнхий орлогод 14,891.8 мянга, улсын төсөвт 113,771.1 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Хэмнэлт үүссэн шалтгаан нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаатай холбоотой байна.

12.2 Сүмбэр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчлүүдийн талаар:

Сүмбэр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **568,327.6** төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **479,012.3** мянган төгрөгийн алдаа, зөрчлийн залруулга хийж, **3,516.7** мянган төгрөгийн төлбөрийн акт бичиж, **7,418.3** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **78,380.3** мянган төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 81.1% буюу **431,454.9** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 18.8% буюу **136,872.7** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 74,064.6 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэсэн байна.
Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн ба АОУС 210 “үнэн зөв байдал”, “үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

- Сумын ИТХ-ын тогтоолгүйгээр Шивээговь сумын Бүжинхэн цэцэрлэгт 26,030.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон зөрчил илэрлээ.
Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 дахь заалтыг зөрчсөн ба АОУС 210 “үнэн зөв байдал”, “үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

